

ХЭНТИЙ АЙМАГ БЭРХ ТОСГОНЫ ЦЭЦЭРЛЭГ

Огноо: 2024.03.19

БЭРХ ХОТЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ХООЛ ХҮНСНИЙ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Бэрх хотын Хүүхдийн цэцэрлэгийн хоол хүнсний
бүтээгдэхүүн нийлүүлэх дэлгүүр сонгон шалгаруулах

Төслийн дугаар: ХЭБХЦ/202401

Харьцуулалт/
гэрээний дугаар:

.....

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хүүхдийн цэцэрлэг нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “**Хүүхдийн цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх**” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг хүсвэл нэмэлт хувийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 20000 төгрөгөөр худалдан авч болно.

Мах махан бүтээгдэхүүн, гурил гурилан, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хуурай хүнс

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоног хүчинтэй.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2024 оны 04 дүгээр сарын 29 -ны өдрийн 16:00 цагаас** өмнө **Цахимаар** ирүүлнэ.

Үнийн саналыг **2024 оны 04 дүгээр сарын 29 -ны өдрийн 16:30 цагт** **НЭЭНЭ.**

Дотоодны давуу эрх тооцох эсэх-**Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Бэрх хүүхдийн цэцэрлэг

Холбоо барих утас: 94040842, 99649680

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> • Стандарт шаардлага хангасан агуулах, хөргүүр, хүнсний бүтээгдэхүүн байрлуулах болон хадгалах тавиурууд, тээвэрлэлтийн зураг хавсаргах. • Ажлын байрны тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлага хангасныг батлах зөвшөөрөл хувьлах. <p>Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн болон татвар төлсөн байдлын мэдээлэл хавсаргах.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2024 оны 04 дугаар сарын 29-ны өдрийн 16:00 цагаас өмнө Бэрх хүүхдийн цэцэрлэг арга зүйчийн өрөөнд</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: 2024 оны 04 дугаар сарын 29 -ны өдрийн 16:30 цагт цэцэрлэгийн урлаг заал</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий хүнсний бүтээгдэхүүнээс бүрдэнэ: Үнийн санал, ТӨӨЗ-ийн 1.1 заасан баримт.</p>

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Мах махан бүтээгдэхүүн, гурил гурилан, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хуурай хүнс
2. **Стандарт:** Мал, махны гарал үүслийн бичигтэй, шинжилгээний бичигтэй, үзлэг, тарилгад хамрагдаж байсан мал эмнэлгийн бичигтэй байх, хадгалалт тээвэрлэлтийн горим зөрчөөгүй, орц нормын стандартыг хангасан, хадгалах хугацаа хэтрээгүй.
3. **Баглаа, боодол:** Мах болон бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэж ирэхдээ цэвэр бүтээлгээр битүү ороож, тоос шороо орохоос сэргийлсэн байх.
4. **Бараа хүргэх газар:** Цэцэрлэг хүнсний агуулах
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Мах	Үхэр, мал эмнэлгийн болон гарал үүслийн бичигтэй, шинжилгээний бичигтэй байх 01-05 сар	1760	кг	Цэцэрлэг			
Мах	Үхэр, мал эмнэлгийн болон гарал үүслийн бичигтэй, шинжилгээний бичигтэй/09-12 сар/	1200	кг	Цэцэрлэг			

Гурил	1-р зэрэг, БГ-050 стандартад багтах, 25кг-ийн савлагаатай	1800	кг	Цэцэрлэг			
Витамин	Витамин-с Нэрс Аньс чацаргана	700	ш	Цэцэрлэг			
Сүү	Пакеттай /Өглөө сүүтэй дүйцэхүйц/	140	ш	Цэцэрлэг			
Каш	Пакеттай	86	кг	Цэцэрлэг			
Аарц	Үнээний/10-04сар/	200	кг	Цэцэрлэг			
Давс	иоджуулсан	60	кг	Цэцэрлэг			
Аз жаргал печень	Монгол	300	ш	Цэцэрлэг			
Төмс	Шар /01-06сар/	800	кг	Цэцэрлэг			
Төмс	Шар/09-12сар/	800	кг	Цэцэрлэг			
Байцаа	Навчит/01-05 сар/	1000	кг	Цэцэрлэг			
Байцаа	Навчит/09-12сар/	530	кг	Цэцэрлэг			
Сонгино	Бөөрөнхий/01-05 сар/	130	кг	Цэцэрлэг			
Сонгино	Бөөрөнхий/09-12сар/	110	кг	Цэцэрлэг			
Лууван	Улаан/01-05 сар/	400	кг	Цэцэрлэг			
Лууван	Улаан/09-12сар/	200	кг	Цэцэрлэг			
Аньс, нэрс, Чацаргана	2 литрийн савтай	31	ш	Цэцэрлэг			
Хатаасан ногоон сонгино	Жижиг савалгаатай /50гр/-тай дүйцхүйц	100	ш	Цэцэрлэг			
Цагаан будaa	хоггүй	220	кг	Цэцэрлэг			
Сахар	Нарийн ширхэгтэй	450	кг	Цэцэрлэг			

Гоймон	Мушгиа /шпагиттай дүйцэхүйц/	80	ш	Цэцэрлэг			
Гоймон	2кг, 5кг-н ууттай /алтан тариа /	40	кг	Цэцэрлэг			
Эсгэгч	Жижиг савлагаатай	18	ш	Цэцэрлэг			
Чавга	хар	30	кг	Цэцэрлэг			
Масло	80%-ийн тослогтой	270	кг	Цэцэрлэг			
Далайн байцаа	Ууттай	72	ш	Цэцэрлэг			
Гурвалжин будaa	хоггүй	50	кг	Цэцэрлэг			
Ургамлын тос		400	ш	Цэцэрлэг			
Үзэм	хоггүй	72	кг	Цэцэрлэг			
Амтлагч	200гр-тай /дашидатай дүйцэхүйц/	140	ш	Цэцэрлэг			
Зөгийн бал	Монгол	70	ш	Цэцэрлэг			
Жимсний чанамал	1л савалгаатай Амтлаг	80	ш	Цэцэрлэг			
Шар будaa	хоггүй	100	кг	Цэцэрлэг			
Шар манжин	Бөөрөнхий 1-5 сар	400	Кг	Цэцэрлэг			
	9-12	300	кг	Цэцэрлэг			
						63,938,000	

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Мах	Үхэр, мал эмнэлгийн болон гарал үүслийн бичигтэй, шинжилгээний бичигтэй /01-06 сар/	Монгол	1760кг	11000	19,360,000		
Мах	Үхэр, мал эмнэлгийн болон гарал үүслийн бичигтэй, шинжилгээний бичигтэй/09-12 сар/	Монгол	1200кг	9000	10,800,000		
Гурил	1-р зэрэг, БГ-050 стандартад багтах, 25кг-ийн савлагаатай	Монгол	1800кг	2200	3,960,000		
Аз жаргал печень	Чанарын шаардлага хангасан	Монгол	300ш	8500	2,550,000		

сүү	Пакеттай \Өглөө сүүтэй дүйцэхүйц\	Монгол	140ш	5000	700,000		
Каш	Пакеттай	Монгол	86кг	4500	387,000		
Аарц	Үнээний/10- 04сар/	Монгол	200кг	6000	1,200,000		
Давс	иоджуулсан	Монгол	60кг	4000	240,000		
Витамин	Аньс Витамин-с Чацаргана Нэрс	Монгол	700ш	500	350,000		
Төмс	Шар /01-05сар/	Монгол	800кг	2000	1,600,000		
Төмс	Шар/09-12сар/	Монгол	800кг	1300	1,040,000		
Байцаа	Навчит/01- 05сар/	Монгол	1000кг	1800	1,800,000		
Байцаа	Навчит/09- 12сар/	Монгол	530кг	2500	1,325,000		
Сонгино	Бөөрөнхий/01- 05сар/	Монгол	130кг	1800	234,000		
Сонгино	Бөөрөнхий/09- 12сар/	Монгол	110кг	2800	308,000		
Лууван	Улаан/01-05 сар/	Монгол	400кг	1800	720,000		
Лууван	Улаан/09- 12сар/	Монгол	200кг	2800	560,000		
Аньс, нэрс, Чацар гана	2 литрийн савтай	Монгол	31ш	32,000	992,000		
Хатаасан ногоон сонгино	Жижиг савалгаатай /50гр/-тай дүйцхүйц	Монгол	100ш	3500	350,000		
Цагаан будaa	хоггүй	Орос	220кг	4000	880,000		
Сахар	Нарийн ширхэгтэй	Орос	450кг	4000	1,800,000		

Гоймон	Мушгиа /шпагиттай дүйцэхүйц/	орос	80ш	4500	360,000		
Гоймон	2кг, 5кг-н ууттай /Алтан тариа/	Орос	40кг	15500	620,000		
Исгэгч	Жижиг савлагаатай	Орос	18 ш	10,000	180,000		
Чавга	хар	Орос	30кг	18000	540,000		
Масло	80%-ийн тослогтой	Орос	270кг	10,000	2,700,000		
Ургамлын тос	1л-ийн савтай Эзэгтэй Олена	Монгол Орос	400	8000	3,200,000		
Үзэм	хоггүй	Орос	72кг	11,500	828,000		
Амтлагч	200гр-тай /дашидатай дүйцэхүйц/	солонгос	140ш	4500	630,000		
Далайн байцаа	Ууттай	солонгос	72ш	4500	324,000		
Гурвалжин будaa	хоггүй	орос	50кг	7000	350,000		
Жимсний чанамал	1л савтай Амтлаг	орос	80ш	7500	600,000		
Шар будaa	хоггүй	орос	100кг	4200	420,000		
Шар манжин	Бөөрөнхий 1-5 сар	монгол	300кг	2500	750,000		
	09-12 сар	монгол	400кг	1800	720,000		
Зөгийн бал	Чанарын шаардлага хангасан	Монгол	70ш	8000	560,000		
							63,938,000

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
 - 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
 - 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
 - 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
 - 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
 - 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[тоо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
 - 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
 - 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
 - 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

- 9. Алданги оногдуулах** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ___-наас _____ оны ___ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]